

**“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2013 оны
санхүүгийн тайлан тэнцлийн дүнг батлах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62.1.9, 96,5 дахь заалт, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” Төрийн Өмчит Хувьцаат Компанийн дүрмийн 8.5.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2013 оны нийт хөрөнгийг 7.420.015.962,95 /Долоон тэрбум дөрвөн зуун хорин сая арван таван мянга есөн зуун жаран хоёр төгрөг ерэн таван мөнгө/ төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг /элэгдэл хассан дүн/ 7.207.318.288,77 /Долоон тэрбум хоёр зуун долоон сая гурван зуун арван найман мянга хоёр зуун наян найман төгрөг далан долоон мөнгө/ төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 212.697.674,18 /Хоёр зуун арван хоёр сая зургаан зуун ерэн долоон мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг арван найман мөнгө/ төгрөгөөр, эзэмшигчийн өмчийг 6.279.373.728,64 /Зургаан тэрбум хоёр зуун далан есөн сая гурван зуун далан гурван мянга долоон зуун хорин найман төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгөөр, нийт авлагыг 68.884.461,96 /Жаран найман сая найман зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун жаран нэгэн төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөгөөр, нийт өр төлбөрийг 1.140.642.234,31 /Нэг тэрбум нэг зуун дөчин сая зургаан зуун дөчин хоёр мянга хоёр зуун гучин дөрвөн төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгөөр санхүүгийн тайлан тэнцлийн дүнг баталсугай.

2.Компанийн 2013 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, 2014 онд өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах, өр төлбөрийг барагдуулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Тулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний

яамыг төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог

төлөөлж:

Р.МӨНХТУЯА

Сангийн яамыг

төлөөлж:

С.ЦЭНД-АЮУШ



H

**“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлын
тайланд дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62.1.13 дэх заалт, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” Төрийн Өмчит Хувьцаат Компанийн дүрмийн 8.5.14 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлын тайланг сонсож компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналт тавьж ажиллах, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулан, ТУЗ-ийн гишүүдийн хариуцлага, идэвхи санаачлагыг дээшлүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Тулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг

төлөөлж:



Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог


төлөөлж:



Р.МӨНХТУЯА

Сангийн яамыг

төлөөлж:



С.ЦЭНД-АЮУШ

**“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр №03 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын
төсөв батлах тухай**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62.1.13 дэх заалт, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” Төрийн Өмчит Хувьцаат Компанийн дүрмийн 8.5.9 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ... тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын төсвийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, мөрдөн ажиллах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д. Тулга/-д үүрэг болгосугай.


**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**


Эрчим хүчний яамыг
төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог
төлөөлж:

Р.МӨНХТУЯА

Сангийн яамыг
төлөөлж:

С.ЦЭНД-АЮУШ



“ӨБЦТС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2014 оны 4 дүгээр сарын 23 ны өдрийн 03
дүгээр тогтоолын хавсралт

“ӨБЦТС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2014 оны зардлын төсөв

№	Зардлын нэр төрөл	Гишүүдийн тоо	Үндсэн цалин	2014		
				4 сар	8 сар	Жил
1	ТУЗ-ийн дарга	1	300	640	2,400	3,040
	ТУЗ-ийн гишүүд	8	250	4,480	16,000	20,480
	ТУЗ-ийн нарийн бичиг	1	200	400	1,600	2,000
	Нийгмийн даатгал, Нийт цалин шимтгэлийн зардал	10		5,520	20,000	3,317.6
2	Бичиг хэрэг					120,0
3	Шатахуун, тослох материал, бусад тээвэр					-
4	Албан томилолт					-
5	ДҮН					28957,6

**“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

№04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
батлах тухай**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62.1.7, 79.1, 81.5.3 дахь заалтууд “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” Төрийн Өмчит Хувьцаат Компанийн дүрмийн 8.5.9 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 04 дүгээр сарын 23 -ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1 “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Ч. Дөлгөөн, Г. Бекболат, И. Лувсанцэрэн, Н. Ууганчимэг, Э. Хангай, Хараат бус гишүүнээр Ц. Баттулга, Ж. Юндэндорж, Ж. Баасандаш нарыг баталсугай.

2. Компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналт тавьж, идэвхи санаачилгатай ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг

төлөөлж:

Д.ДЭЛГЭРЦОГТ

Төрийн өмчийн хороог

төлөөлж:



Р.МӨНХТУЯА

Сангийн яамыг

төлөөлж:

С.ЦЭНД-АЮУШ

8

**“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2014 оны 04 дүгээр сарын 23

№ 01

Улаанбаатар хот


Өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж
дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“... ХЭЛЭЛЦСЭН нь: “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж дүрэмд өөрчлөлт оруулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг ДзДЦС” ТӨХК-иас балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгийн жагсаалт, ажил хүлээлцсэн акт зэргийг дахин хянаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх нь зүйтэй” гэжээ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ  Д.ДЭЛГЭРЦОГТ

